

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХЭМЖИЛ ЗҮЙН БОДЛОГО,
ЭТАЛОНЫ ГАЗАР, ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ШАЛГАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН
ГАЗАРТ МЭРГЭЖИЛТЭН ШАЛГАРУУЛЖ АЖИЛД АВНА.**

Нэг. Зорилго

Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн бодлого, эталоны газар, Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын газарт мэргэшсэн боловсон хүчнийг бэхжүүлэх, шилэн сонгох, сонирхсон төрийн албан хаагч, иргэдээс шалгаруулж нөхөхөд оршино.

Хоёр. Бүртгэл

- Тухайн албан тушаалд тавигдах **боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн албан хаагч, иргэдийг бүртгэнэ.
- Шалгаруулалтанд оролцох төрийн албан хаагч, иргэдийн материалыг Стандартчилал, хэмжил зүйн газрын 2 давхарт 203 “Б” тоот өрөөнд **2015 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн 17.00** цаг хүртэл хүлээн авна.

Гурав. Шалгаруулалтад орохыг хүссэн Төрийн жинхэнэ албан хаагч дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
Үүнд:

- 1) Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
- 2) Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 3) Монгол Улсын иргэний үнэмлэх; */нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/;*
- 4) ШШБЕГ-ийн лавлагаа */Хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх/*
- 5) УБЕГ-ийн лавлагаа */ААНБ-ийн лавлагаа/*
- 6) Оршин суугаа газрын тодорхойлолт
- 7) Давуу тал болох бусад нэмэлт материалууд.

Холбоо барих утас: 261731, 99105614

ТАМГЫН ГАЗАР

2015.08.12